



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/120

Баруун хараа

Малд үзлэг, ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “А” дахь заалт, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 4.5.2, 4.5.3, 4.5.4, 4.5.5, 4.5.6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт, Улсын Их хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчимжсэн үхрийн аж ахуй” хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.25, 2.33 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.16 дахь заалт, аймгийн Засаг даргын 2018 оны А/162 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Бог малын үзлэг, ангилалтыг 2018 оны 05, 06 дугаар саруудад, үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, ашиг шимийн гарцыг тодорхойлон, цэвэр, эрлийз үхрийн тооллогыг 09 дүгээр сард багтаан зохион байгуулж, ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	М. Бямба	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Н. Давааням	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
Гишүүд	Х. Уянга	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
	Л. Занданбат	Хараа 1 дүгээр багийн Засаг дарга
	Б. Түшигжаргал	Баян 2 дугаар багийн Засаг дарга
	Б. Болортуяа	Гонир 3 дугаар багийн Засаг дарга
	Ч. Даваадорж	Батгарьд МЭҮН-ийн захирал
	Н. Эрдэнэбат	Баянтаванэрдэнэ МЭҮН-ийн захирал
	Б. Жаргалсайхан	Дөлгөөн энэрэл МЭҮН-ийн захирал

2. Үзлэг ангилалт хийх малын тоог хавсралтаар баталсугай

3. Үзлэг ангилалтын үр дүнд цөм сүрэг бүрдүүлэн үржлийн мал бойжуулах аж ахуйн нэгж, иргэдийг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулан гэрчилгээ олгохыг ажлын хэсэгт даалгасугай.

4. Үзлэг ангилалтанд хамрагдвал зохих малыг бүрэн хамруулж бог малын үзлэг ангилалтыг 2018 оны 06 дугаар сарын 15, үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, ашиг шимийн гарц тодорхойлон, цэвэр эрлийз үхрийн тооллого хийсэн ажлын тайланг 10 дугаар сарын 25-ын дотор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсүгэй.

5. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б.Эрдэнэбаатар/-т даалгасгай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ

№	Бичлэг	Амжилт хийж өндөр шалгаруу		Урсгал		Хяналтын ажлаа		Хяналтын ажлаа
		Төлөв	Хугацаа	Төлөв	Хугацаа	Төлөв	Хугацаа	
1	Хяналт	100%	200	100%	200	100%	200	100%
2	Бичлэг	100%	200	100%	200	100%	200	100%
3	Бичлэг	100%	200	100%	200	100%	200	100%
4	Бичлэг	100%	200	100%	200	100%	200	100%